



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 5 дугаар
сарын 31-ний өдөр

Дугаар 298

Улаанбаатар
хот

“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг
хэрэгжүүлэх зарим арга
хэмжээний тухай


“Түрээсийн орон сууц” хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн хүрээнд нийслэлийн орон сууцны 7 дугаар хороололд баригдаж байгаа “Бэрэн” ХХК-ийн 223 айлын орон сууцыг төрийн өмчийн түрээсийн орон сууцны санд худалдан авах арга хэмжээ авахыг Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэд зөвшөөрсүгэй.

2. Худалдан авсан орон сууцны үнэ болох 15.0 (арван таван) тэрбум төгрөгийг 2017 оны улсын төсвийн төсөлд тусган шийдвэрлүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэ, Сангийн сайд Б.Болор нарт даалгасугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан төлбөрийг векселиэр баталгаажуулахыг Сангийн сайд Б.Болорт зөвшөөрсүгэй.

4. Векселийн хүүг түрээсийн орон сууцны санд шилжүүлсэн орон сууцны түрээсийн төлбөрөөс бүрдүүлэхийг Барилга, хот байгуулалтын сайд З.Баянсэлэнгэд үүрэг болгосугай.




Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Барилга, хот байгуулалтын сайд 2017. / 116.

З.БАЯНСЭЛЭНГЭ



Төрийн түрээсийн орон сууцны санд шилжүүлэх сууцны тооцоо

	Сууцны талбай, м2	Сууцны тоо, айлаар	Нийт талбай, м2	1м2 талбайн үнэ, төгрөгөөр	Нийт үнэ, төгрөгөөр
1	41.1	37	1520.7	1,880,000.00	2,858,916,000.00
2	39.9	37	1476.3	1,880,000.00	2,775,444,000.00
3	37.9	74	2804.6	1,880,000.00	5,272,648,000.00
4	37.1	37	1372.7	1,880,000.00	2,580,676,000.00
5	21.1	38	801.8	1,880,000.00	1,507,384,000.00
6		223	7976.1	1,880,000.00	14,995,068,000.00

ТҮРЭЭСИЙН 223 АЙЛЫН ОРОН СУУЦ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2016 оны 06 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

"Барилга хот байгуулалтын яам", "Бэрэн групп" ХХК-ийн хооронд 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан "Түрээсийн 223 айлын орон сууц худалдах, худалдан авах гэрээ"-ний 2 дугаар зүйлийн 2.4, 4 дүгээр зүйлийн 4.3, 4.9 дэх заалтыг тус тус үндэслэн "Бэрэн групп" ХХК нь нийт 223 айлын орон сууцыг худалдах, худалдан авах гэрээний дагуу хүлээлгэн өгч, эдгээр орон сууцыг Барилга хот байгуулалтын яам болон Төрийн Орон Сууцны Корпораци ТӨҮГ ЛОСК/- нь барилгын гүйцэтгэл, ажлын чанар, холбогдох бичиг баримтуудтай танилцаад газар дээр нь шалган үзэж энэхүү актаар хүлээн авав.

1. Гэрээлсэн орон сууцны хаяг:

Хангай хотхон, 7-р хороолол, Сүхбаатар дүүрэг, 11-р хороо

2. Тоот: - 514-р байрны 1-144 тоот 144 айлын орон сууц
- 517 –р байрны 1-72 тоот 72 айлын орон сууц
- 515-р байрны 7 айлын орон сууц
Нийт 7975.36 м2, 223 айлын орон сууц

3. Ашиглалтанд орсон огноо 2016 он.

КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН:

Хүлээн авсан:

"БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ"-НЫ
ҮХХЗЗ, ГХО ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ж. БУРМАА

"БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМ"-НЫ
БНАБ ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Л. БИЛЭГЖАРГАЛ

"ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ КОРПОРАЦИ" ТӨҮГ

А. ГАНТУЛГА

Хүлээлгэн өгсөн:

"БЭРЭН ГРУПП" ХХК
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ:

ТӨСЛИЙН АХЛАХ МЕНЕЖЕР:

бүртгэлийн дугаар

ТӨРИЙН ОРОН СУУЦНЫ
КОРПОРАЦИ ТӨҮГ

ХУУЛБАР ҮНЭН

Хуулбар олгосон ахиагчны гарын үсэг

20 11 оны 01 сарын 22 ний өдөр

Б. МӨНХТӨР

Ц. БАТБОЛД

